



## МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1998 оны 19 дугаар  
сарын 30 өдөр

Дугаар А-253

Улаанбаатар  
хот

Өмчийн газрын талаар авах  
зарим арга хэмжээний талаар

1. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Өмчийн газрын гүйцэтгэх үүрэг, ажлын хүрээ зах зээлийн харилцаатай уялдаж өргөжиж байгаатай холбогдуулан тус газрын дүрмийг хэвсрэлтээр баталсугай.
2. Өмчийн газрын үйл ажиллагааны санхүүжилтэнд зориулан төсөвт байгууллагын түрээсийн цэвэр орлогоос 20 хувь, аж ахуйн нэгж байгууллагаас орж буй ногдол ашгаас 20 хувь, өмч хувьчлалын орлогоос 2 хувиар тус тус тооцож санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэн зарцуулж байхыг Өмчийн газар (н.Буянмөнх)-т зөвшөөрсүгэй.
3. Өмчийн газрын орон тоо, бүтэц зохион байгуулалтыг өөрийн үйл ажиллагаатай уялдуулан санхүүжилтийн эх үүсвэрт багаан шийдвэрлэхийг Өмчийн газар (н.Буянмөнх)-т зөвшөөрсүгэй.
4. Энэ захирамж батлагдсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 1997 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн Б/18 дүгээр захирамжийн 1 дүгээр заалт, 1997 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн Б/58 дугаар захирамжийн 1 дүгээр заалтуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ОРЛОГЧ

Я МӨНХӨРГАЛ

137  
Нийслэлийн засаг даргын  
1998 оны 10-р сарын 30-ны  
өдрийн 4-254 тоот захирамжийн  
хавсралт

#### Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Монгол улсын Нийслэлийн Засаг Даргын дэргэдэх Нийслэлийн Өмчийн газар нь (цаашид газар гэнэ) орон нутгийн төрийн өмчит (цаашид төрийн өмчит гэнэ) УҮГ, төсөвт байгууллага болон орон нутгийн төрийн өмчийн (цаашид төрийн өмчийн гэнэ) оролцоотой хуулийн этгээдэд төрийн төлөөлөл хэрэгжүүлэх үүрэг бүхий хэрэгжүүлэх агентлаг хэлбэрээр ажиллах орон нутгийн байгууллага мөн.
- 1.2 Газар нь өөрийн үйл ажиллагаандаа Монгол улсын хууль тогтоомж, удирдах дээд байгууллагын шийдвэр, заавар, журам болон энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.
- 1.3 Газар нь төрийн өмчит УҮГ болон, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засаг санхүү, үйлдвэрийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, тэдгээрийн эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг жил бүр батлах, бүтэц зохион байгуулалтыг сайжруулж үр ашгийг нь дээшлүүлэх, үл хөдлөх хөрөнгийг бүртгэх, баталгаажуулах, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс ногдол ашиг болон түрээсийн төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, үл хөдлөх хөдлөх хөрөнгийг түрээслүүлэх, эзэмшилт ашиглалтанд хяналт тавих, газрын захиалгаар хийгдэх барилга угсралт, их засварын ажлын захиалагчийн үүргийг гүйцэтгэх, шаардлагатай үндсэн хөрөнгийг олж нийлүүлэх, данснаас хасах, бусдад шилжүүлэх зэргээр төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлнэ.
- 1.4 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч газрын даргыг томилж чөлөөлнө.
- 1.5 Газар нь үйл ажиллагаагаа Нийслэлийн Засаг даргын шууд удирдлаганд явуулж, ажлаа тайлагнана.
- 1.6 Газар нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллана.
- 1.7 Газар нь батлагдсан загвараар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

#### Хоёр. Газрын гүйцэтгэх үүрэг

- 2.1 Орон нутгийн өмчийн талаар гарсан төр засгийн бодлого шийдвэр, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэнд нь хяналт тавина.
- 2.2 Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалтын талаар байгууллагын удирдлагатай гэрээ байгуулж биелэлтэнд нь хяналт тавих, үл хөдлөх хөрөнгийн ашиглалтын үр өгөөжийг дээшлүүлэн үргүй зардлыг багасгах арга хэмжээ авна.
- 2.3 Төрийн өмчийн хуулийн этгээдийн эзэмшилд байгаа эд хөрөнгийн эзэмшилт, захиран зарцуулалтын байдалд хяналт тавина.
- 2.4 Төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах, төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөнөөс бусад хөрөнгийн этгээдтэй хамтран хөрөнгө оруулалт хийх, шинээр хамтарсан аж ахуйн нэгж байгуулах, оруулсан

- хөрөнгөө татан авах, төрийн өмчийн хувьцаа, хувь хөрөнгийг худалдах, хувьчлах зэрэг асуудлаар санал боловсруулан шийдвэр гаргуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 2.5 Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчийн сангийн бүртгэл, түүний хөдөлгөөнийг хийх, өмч хөрөнгийн анхан шатны бүртгэл хөтлөлт, тооллого, тайлан тэнцлийг хянан шийдвэр гаргана.
- 2.6 Төрийн өмчийн хүчин чадлын ашиглалт, түүний үр өгөөжийг нэмэгдүүлэх, бизнес төлөвлөгөөг зохиолгож холбогдох байгууллагын дүгнэлтийг гаргуулсаны үндсэн дээр баталж, хэрэгжилтэнд хяналт тавина.
- 2.7 Төрийн өмчит байгууллага дээр өргөтгөл шинэчлэл, их засвар, техник технологийн өөрчлөлттэй холбогдсон хөрөнгө оруулалт хийх асуудлаар холбогдох хэлтэс, газруудтай зөвшилцөн санал боловсруулж шийдвэрлүүлэн түүний хэрэгжилтэнд хяналт тавина.
- 2.8 Төрийн өмчийн тооллогыг явуулах ажлыг зохион байгуулж дүнг нэгтгэнэ.
- 2.9 Төрийн өмчийн хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалт, цалин хөлсний норм, нормативыг холбогдох эрх бүхий байгууллагын санал дүгнэлтийг авсны үндсэн дээр батлан тогтоож өгнө.
- 2.10 Төрийн өмчийг өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд байгууллагад эзэмшүүлэн төлбөр тооцоог хийх, ашиглалтанд нь хяналт тавих ажлыг зохион байгуулж гүйцэтгэнэ.
- 2.11 Хууль тогтоомжид заасан журмын дагуу төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн төлөөлөлийг хэрэгжүүлэх ажлыг зохих шатны Засаг даргатай хамтран зохион байгуулна.
- 2.12 Засаг даргаас томилсон төрийн өмчит үйлдэрийн газрын захиралтай гэрээ байгуулж түүний хэрэгжилтэнд хяналт тавьж үнэлэлт дүгнэлт өгнө.
- 2.13 Төрийн өмчит үйлдэрийн газар болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд удирдах, төлөөлөх үүргийг гүйцэтгэх албан тушаалтныг шилж сонгох, тэднийг мэргэшүүлэх, давтан сургах замаар мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх ажлыг зохион байгуулна.
- 2.14 Төрийн өмчид ногдох ногдол ашиг, түрээсийн төлбөр, өмч хувьчлалаар олсон орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэн хотын хөрөнгө оруулалтын сангийн төлөвлөгдсөн эх үүсвэрийг бүрдүүлнэ.
- 2.15 Нийслэлийн захиалгаар шинээр баригдах болон өргөтгөл шинэчлэлт хийгдэх барилга байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, тооцоо-зургийн даалгаварыг боловсруулан зураг төслийг захиалан хийлгэнэ.
- 2.16 Барилга хөрөнгө оруулалтын талаар гарч буй норм дүрэм, журмыг мөрдөх, сурталчлах, хэрэгжилтэнд хяналт тавих.
- 2.17 Хотын захиалгаар баригдах барилга байгууламж, их засварын ажилд шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээг тооцон, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулах, төлөвлөгдсөн хөрөнгийг төвлөрүүлэх, санхүүжилтийн үйл ажиллагаанд хяналт тавих.
- 2.18 Нийслэлийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэгдэж буй барилга, суртал, их засвар тохижилтын ажлыг мэргэжлийн гүйцэтгэгч байгууллагуудын удирдлагад заавал тендер зарлан шалгаруулж санхүүжүүлж байх.

- 2.19 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр баригдах барилга байгууламж, их засварын ажлыг гүйцэтгэгч байгууллагуудтай хэлцэл хийж, аж ахуйн гэрээ байгуулна.
- 2.20 Гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан гэрээний дагуу хөрөнгө төвлөрүүлж, санхүүжилтйг хугацаанд нь хийх, барилгын технологи чанар,гэрээний үүрэг хариуцлагыг анхаарч ажиллах.
- 2.21 Төрийн өмчийг зүй бусаар үрэгдүүлсэн, төрийн өмчит хуулийн этгээд нь гэрээнд заасан үүргийг хангалтгүй биелүүлсэн, өмч хөрөнгийн холбогдолтой маргааныг шийдвэрлүүлэхэд нэхэмжлэгчээр оролцох.
- 2.22 Төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого,тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж, удирдах төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах
- 2.23 Эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтын дагуу эд хөрөнгийг хувьчлах ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хянах.
- 2.24 Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эрх барих байгууллага болох гишүүдийн хуралд оролцох болон тухайн хуулийн этгээдийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд орох төрийн өмчийн төлөөлөгчийн эрх хэмжээ, түүнийажиллах удирдамж, зааврыг боловсруулж батлуулан хэрэгжилтэнд хяналт тавих.
- 2.25 Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гишүүдийн хурал болон тухайн хуулийн этгээдийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд төрийг төлөөлж орох төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, чөлөөлөх асуудлаар Засаг даргад санал оруулах.
- 2.26 Төрийн өмчийн хорооноос тогтоосон журмын дагуу төрийн өмчийн төлөөлөгчид шагнал урамшуулал олгох асуудлыг шийдвэрлүүлэх.

Гурав.Газрын эрх

- 3.1 Алслагдсан дүүрэгт өөрийн төлөөлөгчтэй байж болох бөгөөд орон нутгийн өмчийн эзэмшилт , ашиглалтанд хяналт тавих.
- 3.2 Төрийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, эзэмшилт, ашиглалтанд тавих хяналтын ажилд шаардлагатай бичиг баримт, мэдээ судалгааг холбогдох байгууллага, албан тушаалаалтанаар гаргуулан авах
- 3.3 Төрийн өмчийг эзэмшигч аж ахуйн нэгжийн холбогдох албан тушаалтан үүргээ биелүүлж чадахгүй байгаа тохиолдолд өөрчлөх санал оруулж шийдвэрлүүлэх.
- 3.4 Барилга байгууламж инженерийн шугам сүлжээний угсралтын ажил батлагдсан зургийг зөрчиж чанаргүй хийгдсэн тохиолдолд ажлыг зогсоож буруутай этгээдийн зардлаар дахин гүйцэтгүүлэх. Хэрэв буруутай этгээд уг зөрчлийг хугацаанд нь арилгаагүй тохиолдолд тухайн байгууллагын үйл ажиллагааг зөрчил арилгатаал зогсоох.
- 3.5 Олгогдсон хөрөнгийг зориулалтын бусаар ашигласан этгээдийг холбогдох банк санхүү хуулийн байгууллагатай хамтран төлбөрийг зохих хууль дүрмийн дагуу барагдуулах
- 3.6 Стандарт, техник, технологийн горим зөрчсөн материал, хийц эдлэл үйлдвэрлэх, нийлүүлэх, ашиглахыг хориглоно.

- 3.7 Мэргэжлийн байгууллагатай тохиролцон барилга захиалагчийн ажилд хяналт шалгалтын ажлыг хамтран явуулах, илэрсэн зөрчил доголдолыг арилгуулж, зохих хууль дүрмийн хариуцлага хүлээлгэх
- 3.8 Бүх төрлийн барилга байгууламж, их засвар, хот тохижилтын ажлыг хийж дууссаны дараа ажлын чанарын баталгааг гүйцэтгэгч байгууллага хариуцах хугацааг тогтоон, ажил бүр дээр баталгаат хугацааны үед хяналт тавьж, гарсан хохирол эвдрэл гэмтлийг арилгуулж байх

### Дөрөв. Газрын удирдлага

- 4.1 Газрын өдөр тутмын үйл ажиллагааг дарга удирдаж зохион байгуулна
- 4.2 Газрын дарга дараахь эрх үүрэгтэй.
  - 1. Газрын дотоод журмыг баталж түүний хэрэгжилтэнд хяналт тавих
  - 2. Газрын нэрийн өмнөөс бусад байгууллагатай харилцах, түүнийг гадаад дотоодод төлөөлөх
  - 3. Нийслэлийн өмчийн харилцааны хэтийн төлөв байдалд, стратеги төлөвлөлт, бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээг удирдан зохион байгуулах
  - 4. Батлагдсан орон тоонд багтаан газрын ажилтаныг томилох, чөлөөлөх, түүнд цалин хөлс олгох, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэх.
  - 5. Засаг даргын нэрийн өмнөөс төрийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай гэрээ байгуулах
  - 6. Удирдах дээд байгууллагаас тогтоосон эрх хэмжээний хязгаарын дотор газрын хөрөнгийг захиран зарцуулах.
  - 7. Төрийн өмчийн төлөөлөгчид шагнал урамшуулал олгох
  - 8. Эрх хэмжээний асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн газрын хэмжээнд дагаж мөрдөх тушаал, заавар, журам гаргах
  - 9. Хууль тогтоомжид заасан бусад эрх үүрэг
  - 10. Үл хөдлөх хөрөнгийн түрээс, ногдол ашиг, бусад орлогыг батлагдсан төлөвлөгөөнөөс давуулан биелүүлсэн тохиолдолд давуулсан орлогыг өөртөө үлдээх.
  - 11. Нийслэл дэхь төрийн өмчийг бүртгэх, баталгаажуулах.
  - 12. Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хөрөнгийн ашиглалт, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, шилжилтийн байдалд хяналт шалгалт хийх.
  - 13. Төрийн өмчит байгууллагуудыг нэн шаардлагатай үндсэн хөрөнгөөр хангах

### Тав.Газрын санхүүжилт

- 5.1 Газрын санхүүжилтийн эх үүсвэр нь үл хөдлөх хөрөнгийн түрээсийн орлого болон төрийн төлөөлөлийн орлого(ногдол ашиг), өмч хувьчлалын орлогоос тогтоосон хувиар авах шимтгэл болон, бусад орлогоос бүрдэнэ.
- 5.2 Төрийн өмчит үйлдвэрийн газрын татвар төлсний дараахь ашиг, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчид ногдох ногдол ашиг, өмч хувьчлалын орлого болон бусад эх үүсвэрээс хотын төсөвт төвлөрүүлж буй хөрөнгөөс шимтгэл авна.
- 5.3 газрын санаачилгаар бусад үйл ажиллагаанаас орсон орлогыг газар өөрөө захиран зарцуулна.